



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/252

Номгон

Хаврын улиралд мод тарих ажлыг
зохион байгуулах тухай

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 31 дүгээр зүйлийн 31.1, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. “Тэрбум мод таны тарьсан нэг модноос эхэлнэ” уриан дор 2023 оны хаврын улиралд мод тарих ажлыг 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Мод тарих талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, өмнөх онд тарьсан модыг услах, арчлах, нөхөн тариалалт хийх ажлыг зохион байгуулж, холбогдох санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагыг мод тарих ажилд өргөнөөр татан оролцуулах, мэргэжил арга зүйгээр хангах, тарьсан модыг бүртгэлжүүлэхийг ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Модлог ургамлын тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг төв талбайд зохион байгуулж ажиллахыг Сум дундын ойн анги Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (П.Уртнасан), “Баянхонгор тохижилт үйлчилгээ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Т.Отгонбаатар) тус тус үүрэг болгосугай.


641310621

2.

5.“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд айл өрх бүр хашаандаа 5-аас доошгүй мод, албан байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгчид өөрийн эзэмшил газрын 10 хувиас доошгүй газарт мод, сөөг тарих, ногоон байгууламж байгуулах, хэрэв боломжгүй тохиолдолд сумын Засаг даргын Тамгын газраас хуваарилсан талбайд дүйцүүлэн мод тарихыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

6.“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээ тайланг нэгтгэж 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН